



БАТЛАВ

ТЭЛМЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Барилга угсралтын ажлыг дулааны улиралд хийхээр тооцоологдсон байгаа тул БН ба Д 51.02.05, БН ба Д 52.02.05-н заалтыг баримтлан гүйцэтгэнэ.

Барилга угсралтын ажил гүйцэтгэх үе шатны ажлын график Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал: Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ. Барилгын ажлын явцад ямар нэгэн ойлгомжгүй зөрчилдөх зүйл илрэх аваас заавал Зохиогчид мэдэгдэж байх ёстой. Бүх үе шатны ажлуудад тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулан, ил далд ажлын акт үйлдэж баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэсэн байна. Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д 3.02.01 -90-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ. Уг барилга нь Тэлмэн сумын төвд байрлах ба 18*24м хэмжээтэй Соёлын төвийн барилгаар ашиглагддаг. Гадна фасад, хучилт дээврийн ажил:

Одоо байгаа гадна фасад муудаж өнгө тоосго унасан, цууралт өгсөн. Барилгын хана хөөсөнцрөөр дулаалах /10см/ дулаалгын хөөсөнцөр дээр түрхлэг хийх. Өнгөлгөө нь Соёлын өв түүх дурсгалын зураг орсон байна. Соёлын төв гэж харагдахуйц өвөрмөц байна. Гоёлын хөөсөн багана /50см өргөн / . Гадна гэрэлтүүлэгч угсрах. Гадна хаалга суулгах /4 ш/ бороо салхинд гандахгүй, дулаан алдагдалгүй сайн хаалга байх, дээврийн хучилт муудаж дусаал ордог. Урд хэсгийг бүрэн буулгаж шинээр дээврийн 1 үе цутгамал хийж, 3 дээш үе наамал хар цаас уур тусгаарлагч хийнэ. Усны уналтыг тодорхойлж хоолойг шинээр хийх .

Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч эрхийнхээ дагуу ажлыг зогсоож зөрчлийг арилгуулсны үндсэн дээр засварын ажлыг үргэлжлүүлнэ. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь: Монгол улсын Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн "Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага" гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө. Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн

заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ. Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.